Хотын стандарт, хяналтын газрын 2023 оны 10 дугаар сарын 23-ний өдрийн 01/1330 дугаар албан бичгийн хавсралт

2023011029 ...351 СБТ17029

# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

(2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар)

2023 оны 10 дугаар сарын 20 Улаанбаатар хот

| Д/д | ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр сая төгрөг | Нийт хөрөнгийн хэмжээ(сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтод 2023 он: Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Зорилтод 2023 он: Төсөв (Сая.төг) | Зорилтод 2023 он: Төсвийн (Гүйцэтгэл (сая.төг) | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | |
| **5.1 Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, хотыг цэцэрлэгжүүлэх, ойжуулах, тохижилт бүхий гудамж, талбайг бий болгож, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | | | | | |
| 1 | 5.1.2 Хотын тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ. | 209 | 5.1.2.1.Иргэд, олон нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад | 2021-2024 | УБЗААХСХГ Дүүргүүд | УНТ | 21,745.7 | Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбай 23. | Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг 9-өөр нэмэгдүүлсэн байна. | 5,400.0 | - | **2023 онд:** Нийслэлийн хэмжээнд шинээр бүтээн байгуулалтаар хийгдсэн 10 спорт, хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлыг ашиглалтад хүлээн авсан. Мөн нийтийн эзэмшлийн орон сууцны барилга, хотхон болон гэр хорооллын гудамжинд байрлах 474 хүүхдийн тоглоомын талбайд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн.<br>**Үр дүн:** Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ТӨААТҮГ, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ийн захиалагчийн | 70 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулна. | | | | | | | | | хяналтаар хийгдсэн нийт 20 тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс 3*3 сагсан бөмбөгийн талбай-4, хүүхдийн тоглоомын талбай-6, нийт 10 тохижилтыг ажлыг ашиглалтад хүлээн авч дүгнэлт баталгаажуулсан.<br>- Хотын стандарт, хяналтын газрын даргын 2023 оны 02-13-04/023/03 дугаартай “Стандартын шаардлага хангахгүй эрсдэлтэй хүүхдийн тоглоомын талбайд урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу нийт 474 байршилд орчны аюулгүй байдлыг хангуулах урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар хүүхдийн тоглоомын талбайн эзэмшигч, ашиглагч байгууллагуудад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн 81 зөвлөмж хүргүүлж, 26 тоглоомын талбайн ашиглалт сайжирч, 3 тоглоомын талбайг дүүргийн төсвийн хөрөнгөөр засаж сайжруулсан байна. | |
| **5.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангана.** | | | | | | | | | | | | | |
| 2 | 5.3.4. Хүн ам төвлөрөн суурьшсан бүс нутаг, хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуулын судалгааг улсын болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, эрэлт хэрэгцээ, захиалгад үндэслэн хийж, газрын доорх | 257 | Ундны усны эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тодорхойлж, хил хязгаарын дагуу стандарт хангасан хашаа барьж, эрүүл ахуйн бүсийг хамгаална. | 2022-2024 | УСУГ ХСХГ | Нийслэлийн төсөв | - | - | Ундны усны эх үүсвэрийг хамгаалах 8 км хашаа барьсан байна. | 1098.4 | - | **2023 онд:** Ундны усны эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хашаажуулах ажлын талаар Ус сувгийн удирдах газраас арга хэмжээний талаар хэрэгжүүлж буй ажлын мэдээлэл авч хамтран ажиллаж байна.<br>**Үр дүн:** Улаанбаатар хотын ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-т 01/727 дугаартай албан бичиг хүргүүлэн нийслэлийн ус хангамжийн Дээд болон Төвийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс дэх 1,3 км газарт урьд ашиглагдаж байсан авто замын төмөр хашлагыг зөөж суурилуулах, мөн гүний худгуудын торон хашааг сэлбэж засварлах ажлыг гүйцэтгэхээр ажиллаж байна. Мөн | 70 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | усны ашиглах боломжит нөөцийг тогтоох ажлыг хэрэгжүүлнэ. | | | | | | | | | | | Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах талаар боловсруулж буй бодлогын баримт бичигт Улаанбаатар хотын ундны усны 11 эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах, хамгаалахтай холбоотойгоор улсын тусгай хэрэгцээнд авах, хашаажуулах талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 01/373 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн. | |
| 3 | 5.3.6.Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах стандартыг мөрдүүлнэ. | 267 | 5.3.6.1.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, аятухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ | 2021-2024 | ХСХГ УСУГ НБОГ | НТ | 200.0 | - | Ундны усны эх үүсвэрийг хамгаалах, Үерийн усны барилга байгууламж,ус хуримтлуулах хөв цөөрөм /биосвайл/ үүсгэх, ус дахин ашиглах тухай удирдамж, баталсан 2 гарын авлагыг иргэд ААНБ-уудад сурталчлан таниулсан байна. | 50.0 | - | **2023 онд:** "Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага", "Хөв цөөрөм үүсгэх болон хур тундасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага" хотын стандартын 2 төслийг боловсруулж хянан тохиолдуулж байна.<br>**Үр дүн:** 2023 онд багтаан хотын стандартын төсөлд холбогдох мэргэжлийн байгууллагууд, иргэд олон нийтээс санал авах хэлэлцүүлэг зохион байгуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 70 |
| 4 | | 268 | 5.3.6.1.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, аятухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг | 2021-2024 | ХСХГ УБЗАА | НТ | 150.0 | - | Ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага, төлөвлөлт хийх удирдамж, 2 арга | 50.0 | - | **2023 онд:** Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 20 дугаар тогтоолоор "Ногоон байгууламж" бүлгийн 5 хотын стандарт батлагдаж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн.<br>**Үр дүн:** Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах | 70 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсруулж, мөрдүүлнэ | | | | | | зүйн баримт бичиг боловсруулсан байна. | | | зарим арга хэмжээний тухай" А/242 дугаар захирамжийн хүрээнд "Ногоон байгууламж" бүлгийн 5 хотын стандартын талаарх мэдлэг ойлголт өгөх сургалтад нийт 290 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хамруулав. | |
| 5 | | 269 | 5.3.6.1.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, аятухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ | 2022-2023 | ХСХГ УБЗАА | НТ | 50.0 | - | Хот доторх оршуулгын үйл ажиллагаа явуулдаг газрын орчны цэцэрлэгүүлэлтийн орчны аюулгүй байдлын баримт бичгийн төслийг батлуулсан байна. | 20.0 | - | **2023 онд:** "Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага" хотын стандартын төслийн боловсруулж хянан тохиолдуулж байна.<br>**Үр дүн:** 2023 онд багтаан хотын стандартын төсөлд холбогдох мэргэжлийн байгууллагууд, иргэд, олон нийтээс санал авах хэлэлцүүлэг зохион байгуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 70 |
| 6 | | 270 | 5.3.6.1.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, аятухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ | 2022-2023 | ХСХГ НБОГ | НТ | 50.0 | - | Уул уурхайн ол олборлолтын улмаас эвдэрсэн газрын хөрсөнд дахин сэргээлт хийх ерөнхий шаардлага, удирдамж арга зүйн баримт бичгийн төслийг батлуулсан байна. | 20.0 | - | **2023 онд:** "Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн гарын авлага" хотын стандартын төслийг боловсруулж хянан тохиолдуулж байна.<br>**Үр дүн:** 2023 онд багтаан хотын стандартын төсөлд холбогдох мэргэжлийн байгууллагууд, иргэд, олон нийтээс санал авах хэлэлцүүлэг зохион байгуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 70 |
| **6.1. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрөлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.** | | | | | | | | | | | | | |
| 7 | 6.1.3.Хот байгуулалтын | 283 | 6.1.3.1.Хот байгуулалтын | 2022-2023 | ХСХГ НМТГ | НТ | 400.0 | - | Хот байгуулалтын | 200.0 | | **2023 онд:** Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар | 90 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгоно. | | | | | | кадастрын мэдээллийн системийг бүрэн ашиглалтад оруулсан байна. | | | олгох, барилга барих үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/60 тушаалаар байгуулагдсан төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгах, үйлчилгээг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсэгт ажиллаж холбогдох байгууллагуудад санал өгөх, чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах байна.<br>**Үр дүн:** Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгавар “Шил” ажиллагааны хэрэгжилтийг хангуулан ашиглалтад орсон нийт 801 барилга байгууламжийн дүгнэлт мэдээллийг info@shilen.gov.mn цахим сайтад байршуулж иргэдэд нээлттэй ил тод болгосон. | |
| 8 | 6.1.5.Хотын стандарт, норм дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж , мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 297 | 6.1.5.1.Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөгдөх стандартыг хангуулах шаардлагуудыг боловсруулж мөрдүүлнэ. | 2021-2024 | ХСХГ | НТ | 533.5 | Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөгдөх стандартыг хангуулах 22 багц боловсруулсан. | Стандартыг ханлуулах 5 багц шаардлагыг боловсруулсан байна. | 122.0 | - | **2023 онд:** Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөх 114 хотын стандартын төсөл боловсруулсан. Үүнээс 2022 онд 9 бүлгийн 38, 2023 онд 7 бүлгийн 14 хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. 2023 онд 7 бүлгийн 17 хотын стандартыг төсөл боловсруулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>**Үр дүн:** Хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар удирдамж, нэгдсэн төлөвлөгөө батлуулсан. Төлөвлөгөөнд хотын стандартыг сурталчлах, зөвлөмж арга зүйгээр хангах, судалгаа хийх, хяналт шалгалт гэсэн үндсэн 4 чиглэлээр нийт 126 арга хэмжээ тусган хэрэгжилтийг хангуулж байна. Үүнд: | 90 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | - Хотын стандартын талаарх мэдлэг, ойлголт өгөх сургалтыг нийт 13 удаа зохион байгуулж нийт 1506 албан хаагч, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг хамруулсан.<br>- Нийслэлийн хэмжээнд нийт 382 байршилд барилгын түр байгаагаас 197 байршлын 751 объектод хяналт шалгалт хийсэн. Тус хяналт шалгалтаар улсын /ахлах/ байцаагчийн 117 зөвлөмж, 27 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлж барилгын түр хашааны стандартыг хангуулсан.<br>- Нийслэлийн хэмжээнд барилга угсралт, зураг төсөл, ашиглалт, чанар аюулгүй байдал хянал шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор улсын /ахлах/ байцаагчийн нийт 458 мэдэгдлийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд: -барилгын угсралтын чиглэлээр 266, -зураг төслийн чиглэлээр 92, -материал үйлдвэрлэгч 100. | |
| 9 | | 298 | 6.1.5.2.Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартад нийцүүлнэ. | 2022-2024 | НОСК ХСХГ НХБХГ | - | - | Стандартад нийцсэн төрийн болон нийгмийн үйлчилгээний 40 барилга байна. | Төрийн болон нийгмийн үйлчилгээний 45 барилгыг стандартад нийцүүлсэн байна. | - | - | **2023 онд:** Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагын төлөөллийг тогтмол оролцуулж байна.<br>**Үр дүн:** - Нийслэлийн хэмжээнд төрийн болон нийгмийн үйлчилгээний нийт 55 барилгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй, стандартын шаардлагын дагуу болгох үүрэг даалгавар өгч, биелэлтийг хянаж байнгын ашиглалтад | 90 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | оруулсан. Үүнд: сургууль-20, цэцэрлэг-30, төрийн байгууллага-5 тус тус байна. - Барилгын угсралт, зураг төслийн ажилд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй төлөвлөлтийг нэмэгдүүлэх зорилгоор зураг төсөл зохиогч нийт 46 аж ахуйн нэгж байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх тухай улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлсэн. | |
| | **Дундаж биелэлт:** | | | | | | | | | | | | **76.6** |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Э.ДАВААХАТАН

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХЭЭ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН М.ГАЧМАА